

Компанийн нэр: МТЗ ТӨХК

Тайлант огноо: 2015.12.31

2016 оны ... сарын ...

	Сорил хийсэн дансны нэр	Аудитаас өгсөн зөвлөмж	Хариуцах албан тушаалтан	Зөвлөмжийн биелэлт
1	НӨАТ-ын бүртгэл болон татварын шалгалтаар тавигдсан актны талаар	<p>НӨАТ-ын дансны үлдэгдэл 2014 оны 12 сарын 31-ний байдлаар 17 тэрбум төгрөгийн татварын буцаалтын авлагатай байна. Үйлчлүүлэгч НӨАТ-ын буцаалтыг бэлнээр авахаар хүсэлт гаргасан учир татварын үлдэгдэл баталгаажуулах татварын шалгалт хийгдсэн байна. Татварын үлдэгдэл баталгаажуулах шалгалтаар тус байгууллагын 18 тэрбум төгрөгийн буцаалтыг хүчингүй болгосон ба илүү төлөлтөөс нь 866 сая төгрөгийг буцаахаар шийдвэрлэж дансанд нь төлсөн байна. Компани 18 тэрбум төгрөгийн буцаалтыг хүчингүй болгосон татварын актыг зөвшөөрөхгүй байгаа ба асуудлаа шийдвэрлүүлэхээр татварын маргаан таслах зөвлөлд хандсан бөгөөд асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. Энэхүү татварын шалгалттай холбогдон дараах асуудлууд үүсч байна.</p> <p>1.Татварын шалгалтаар 18 тэрбум төгрөгийн буцаах бичилтийг хүчингүй болгосноос шалтгаалан бүртгэлдээ залруулга хийсэн боловч 15 тэрбум төгрөгөөр залруулсан байна. Яагаад өөр дүн байгаа талаар шалгаж үзэхэд татварын албаны бүртгэлийн үлдэгдэлтэй өөрийн байгууллагын үлдэгдэл тохируулах зорилгоор өөр дүнгээр залруулсан байна.</p> <p>2.15 тэрбум төгрөгөөр буцаах бичилт хийсэн боловч оны эцэст яг ийм төрлийн 9 тэрбум төгрөгийн авлагын бичилтийг хийсэн. Мөн НӨАТ-ын залруулга гэж 233 орчим сая төгрөгөөр залруулга хийсэн байна. Залруулгыг хийхдээ ямар нэг тооцоололд үндэслээгүй ба яагаад хийсэн шалтгаан нь тодорхой бус байна.</p> <p>3.Бидний тооцоолж байгаагаар үйлчлүүлэгч татвар илүү төлөөгүй ба татварын буцаалт бэлнээр төлөгдөх үндэслэл байхгүй байсан</p>		<p>1.Дутуу залруулсан дүнг зөв болгон засварласан.</p> <p>2. Татварын маргаан таслах зөвлөлийн шийдвэр нь ТУБ-ын актын дүнг хэвээр үлдээсэн. Улмаар манай компани шийдвэрийг эс зөвшөөрч одоогоор Нийслэлийн иргэний хэргийн шүүхэд гомдол гаргасан байгаа. Цаашид авах арга хэмжээний талаар санал:</p> <ul style="list-style-type: none"> - <i>ТМТЗ-ийн хурлыг хүлээж, гомдлыг дахин хэлэлцүүлж эцсийн шийдвэрийг гаргуулах;</i> - <i>Холбогдох нотлох баримтыг бүрдүүлэн харъяаллын шүүхэд нэхэмжлэл гаргаж, шүүхийн журмаар маргааныг шийдвэрлүүлэх</i>

		учраас бид татварын байцаагчийн тооцооллын хуудсыг шалгаж үзэхэд алдаа байсан. Тооцооллыг дараах байдлаар харууллаа. /Хавсралт 1/												
2	Алдангийн орлогын бүртгэлийн талаар	Үйлчлүүлэгч өөрийн эзэмшилд байдаг 245 ачааны вагоныг “УБТЗ” ХНН-д түрээслэдэг. Түрээсийн гэрээнд төлбөрөө хугацаандаа төлөөгүй бол төлөгдөөгүй хоног тутамд 0.1-0.2 хувийн алданги тооцно гэж, мөн эсрэг тохиолдолд түрээслэгчийн санаачлагаар гэрээг зогсоож болох ба энэ өдрөөс эхлэн түрээсийг тооцохгүй гэж тооцсон байна. Түрээс зогссон өдрөөс үйлчлүүлэгч түрээслэгчид “УБТЗ” ХНН-ийн даргын баталсан “Ачаа тээвэрлэлтийн тариф”-ын дагуу зам эзэлгээний төлбөр болох 20000 төгрөгийг вагон тутамд өдөр бүр төлөхөөр байна. Түрээсийн гэрээний дагуу төлбөрөө хугацаандаа төлөөгүй алдангийг тооцож түрээслэгчээс 722 сая төгрөгийн алдангийн авлага бүртгэж орлогоор тайлагнасан байна. Харин түрээсийн гэрээний нөгөө хэсэг болох түрээслэггүй үеийн зам эзэлгээний төлбөрийг өглөгөөр бүртгээгүй байна. Өглөгийг 1 тэрбум төгрөгөөр тооцож үүнээс 2014 онд үүссэн 321 сая төгрөгийг тайлант үеийн зардлаар бүртгэсэн ба 2015 онд ногдох 679 орчим сая төгрөгийг зардлаар бүртгээгүй байна. Хоёр тал энэ асуудлаар удаа дараа ярилцаж байгаа ба удирдлагуудын түвшинд хурал болж алданги болон зам эзэлгээний төлбөрийг хоёр талаасаа нэхэмжлэхгүй байхаар тохирсон байна. Гэхдээ энэ шийдвэр нь албан бус байна. Алдангийн авлага өглөгийг тулган баталгаажуулах захидлаар баталгаажуулахад “УБТЗ” ХНН нь тус байгууллагатай алданги болон зам эзэлгээний төлбөрийн тооцоо байхгүй гэсэн хариу илгээсэн.		УБТЗ ХНН-тэй энэхүү асуудлаар олон удаа уулзаж зарчмын асуудлаар удирдлагын түвшинд тохиролцсон боловч, зам эзэлгээний төлбөрийг УБТЗ ХНН манайхаас авах авлагаар санхүүгийн бүртгэлдээ бүртгээгүй, тооцоог эцэслэн харилцан зөвшөөрсөн акт хийгдэж чадаагүйгээс 2015 оны санхүүгийн тайланд зардлыг хүлээн зөвшөөрөөгүй. Хоёр байгууллагын хооронд 2014 онд хийгдсэн манай талаас түрээсийн төлбөрийн хэтэрсэн хугацаанд алданги тооцохгүй байх, нөгөө талаас зам эзэлгээний төлбөр тооцохгүй байх протокол, УБТЗ ХНН-ээс ирүүлсэн 2015 оны зам эзэлгээний төлбөрийн нэхэмжлэхийн дүнг тус тус үндэслэж зардлыг авлагын дүнд ноогдох хэсгийн дүнгээр хүлээн зөвшөөрч бүртгэхээр 2 талаас ажиллаж байна.										
3	Татварын хойшлогдсон хөрөнгө, өр төлбөрийн талаар	Тайлант онд татварын хойшлогдсон хөрөнгө дансны хөдөлгөөн дараах байдалтай байна. <table border="1" data-bbox="347 1085 1120 1252"> <tr> <td></td> <td>/мянган төгрөгөөр/</td> </tr> <tr> <td>Эхний үлдэгдэл</td> <td>553,577.7</td> </tr> <tr> <td>Нэмэгдсэн</td> <td>-</td> </tr> <tr> <td>Буурсан</td> <td>329,168.6</td> </tr> <tr> <td>Эцсийн үлдэгдэл</td> <td>224,409.1</td> </tr> </table> Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийн бичилт бичигдсэнтэй шууд холбоотойгоор ААНОАТ-ын өглөг давхар бүртгэгдсэн байна. СТОУС 12.3-т /Орлогын татварын стандарт/ Ирээдүйд тухайн компани үүсгэсэн татварын хөрөнгийг ашиглах хэмжээний		/мянган төгрөгөөр/	Эхний үлдэгдэл	553,577.7	Нэмэгдсэн	-	Буурсан	329,168.6	Эцсийн үлдэгдэл	224,409.1		Зөвлөмжийг хэрэгжүүлж ААНОАТ-ын өглөгийн дансыг 497,338 мянган төгрөгөөр, хойшлогдсон татварын хөрөнгө дансыг 224,409 мянган төгрөгөөр тус тус бууруулж залруулж бичсэн.
	/мянган төгрөгөөр/													
Эхний үлдэгдэл	553,577.7													
Нэмэгдсэн	-													
Буурсан	329,168.6													
Эцсийн үлдэгдэл	224,409.1													

		ашигтай ажиллах нь тодорхой үед “хойшлогдсон татварын хөрөнгийг” бүртгэнэ гэж заасан. Үйчлүүлэгч компани нь 500-200 сая төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгө ашиглах хэмжээний ашигтай ажиллах хэтийн төлөв ажиглагдахгүй байгаа ба төмөр замууд баригдаж дууссаны дараа үндсэн үйл ажиллагааны орлогоо олж эхлэх боломжтой гэж төлөвлөгдөж байгаа болно.		
4	Өглөгийн бүртгэлийн талаар	Үйлчлүүлэгчийн төмөр зам барих төслийн үндсэн санхүүжилт зогссонтой холбогдон зам бариулах, хяналт хийлгэх, зөвлөх үйлчилгээ авах зэрэг ажлууд давхар зогссон байна. Нэгэнт санхүүжилт байхгүй учир гэрээ гүйцэтгэгчиддээ ажил гүйцэтгэлийн төлбөрийг төлж чадахгүй зогсоосон байна. Ихэнх харилцагчид ажлын гүйцэтгэлийг дүгнэсэн акт, ажлын тайлангаа үндсэн баримт болгож төлбөр нэхэмжилж байна. Гэвч байгууллага өглөгөө бүртгээгүй байна. Одоогийн байдлаар нэхэмжлэгдэж байгаа төлбөрийг дэлгэрэнгүйгээр харууллаа. /Хавсралт 2/ Бүртгэхгүй байгаа шалтгааныг асуухад төлбөрөө төлөхөөрөө бүртгэнэ гэсэн бодлоготой байгаа. Ер нь манайх төлбөр төлдөггүй МУ-ын ХБанк төлдөг харин манай байгууллага төлбөр төлөгдсөн үед нь шууд засгийн газрын хөрөнгө оруулалтаар бүртгэдэг гэж тайлбарлаж байгаа. Бүртгэгдээгүй байгаа алданги ойролцоогоор 4.9 тэрбум төгрөг, өглөг 63.9 тэрбум төгрөг байна.		“Шинэ төмөр зам” төслийн хүрээнд хийгдэх ажлын эхний ээлжийн санхүүжилт болох 28, 82-р тогтоолын дагуу 55 сая, 200 сая ам.долларын тус бүр санхүүжилт хийгдэхээс 22.5 сая, 197.2 сая ам.долларын санхүүжилт хийгдэж уг тогтоолын хавсралтад заагдсан ажлуудын гүйцэтгэлийг хүлээн авч баталгаажуулан, ЗТЯ-нд хүргүүлэн Хөгжлийн банкнаас төлбөрийг шилжүүлж, бүртгэлдээ бүртгэдэг байсан. Зөвлөмжийн дагуу өр төлбөрийг ТУЗ-д танилцуулсан. Тодорхой шийдэлд хүрээгүй байна.
5	Тасралтгүй үйл ажиллагаа	Аудит хийх үеийн байдлаарх байгууллагын үйл ажиллагааны байдал, төрөөс хэрэгжүүлж байгаа үйлдэл, санхүүгийн тайлангаарх алдагдал зэргийг нь харахад үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа ирээдүйд тасралтгүй явагдах эсэх нь эргэлзээтэй харагдаж байна. Тайлант онд байгууллага өөрийн вагонуудыг “УБТЗ” ХНН-д түрээслэж 1.2 тэрбум төгрөгийн орлого, харилцах дансанд байгаа 13 тэрбум төгрөгийн үлдэгдлээс 579 сая төгрөгийн хүүгийн орлого олсон байна. Түрээсийн орлого нь байнга байх магадлал муутай хэрвээ “УБТЗ” ХНН эдгээр вагонуудыг түрээслэхгүй л гэвэл шууд орлогогүй болох магадлал өндөр байна. Харилцах дансанд байгаа мөнгийг энэ маягаараа ажиллавал 3-н жилийн дараа ашиглаж дуусахаар байна. Энэ бодит байдалд үндэслэн бид тухайн компанийн ирээдүйн мөнгөн урсгалыг төсөөлж үзвэл дараах байдалтай байна. /Хавсралт 3/ Бид мөнгөн урсгалыг төсөөлөхдөө дараах хэдэн өөдрөг үзэл		Зөвлөмжийг анхаарч ажиллаж байна. 2016 оны 3-р сараас Замын-Үүдийн шилжүүлэн ачих цогцолборыг УБТЗ ХНН-д түрээсэлсэн, 5-р сард Төмөртэйн 23,4 км-ын урттай төмөр замыг хүлээн авч өөрийн зүтгүүрээр тээврийн үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь 2015 онтой харьцуулахад орлого нэмэгдэж байна.

6		<p>баримтлалыг ашигласан болно. Үүнд: 1.Түрээсийн орлого буурахгүй “УБТЗ” ХНН нь байнга түрээслэнэ 2.Цалин болон бусад зардал нэмэгдэхгүй 3.Валютын ханш ирээдүйн 3 жилд тогтмол байна. Гэвч энэ төсөөллөөр тооцоход 2019 он гэхэд байгууллага мөнгөний дутагдалд орохоор байна.</p>		
7	<p>Бүртгэгдээгүй хөрөнгө болон өр төлбөрийн талаар</p>	<p>Өмнөх аудитын зөвлөмжийн 1.3-д, ЗТЯ-ны ХШҮДАГ-ын тайлангийн 13.1.4-д тус компани нь нийт 64.3 сая ам.долларын зээлийг БНХАУ-ын Экспорт-Импортын банкнаас авч хөрөнгө бэлтгэсэн боловч 35.7 сая ам.долларын хөрөнгийг өглөгөөр бүртгэлдээ тусгасан ба үлдэх 28.6 сая ам.долларыг бүртгээгүй байна. Бид зээлийн гэрээг үзэх гэсэн боловч цагдаагийн газар хураагдсан учир чадаагүй. Үйлчлүүлэгчээс бүртгэхгүй байгаа шалтгааныг асуухад манайд ашиглах боломжгүй хөрөнгө учраас бүртгээгүй гэсэн хариултыг өгч байна.</p>		<p>Монгол Улсын Сангийн яам, Зам тээврийн яам, БНХАУ-ын ЭКСИМ банкны хооронд хийгдсэн хөнгөлөлттэй зээлийн гэрээний хөрөнгөөр ТЗ-ын зам арчилгааны тоног төрөөмжүүд нь одоогоор манай компанийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх боломжгүй байгаа бөгөөд энэ талаар Зам, тээврийн яаманд удаа дараа албан журмаар хүргүүлж танилцуулсан.</p>

